

## ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тус баримт бичиг нь хөгжлийн Алсын хараа, Стратегийн зорилго, тэдгээрийн Зорилтууд, бодлогыг хэрэгжүүлэх Үе шат, Хүрэх үр дүн, дагалдах Дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр зэрэг үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын хамрах хүрээ нь анхдагч эрчим хүчний олборлолт, нөөц бүрдүүлэлт, эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлт, хангалтын үйл ажилгаа, эдгээрийн удирдлага зохион байгуулалтын салбаруудыг хамрах ба хугацааны хувьд Алсын хараа, стртегийн зорилго, зорилтууд – 15 жил хүртэл (2015-2030 он), Дунд хугацааны хөтөлбөр 4-8 жил хүртэл байхаар төлөвлөж байна.

Аль ч орон эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогоо тодорхойлохдоо Аюулгүй байдал, Үр ашиг, Байгаль орчин гэсэн үндсэн хүчин зүйлсийг анхаарч тулгуур зарчимаа тодорхойлсон байдаг. Үүнээс үндэслэн төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогын стратегийн зорилго, зорилтуудийг томъёолох тулгуур зарчмуудыг тодорхойсон болно. Стратегийн зорилго нь зорилтууд болж задрах ба зорилтуудаар дэвшүүлсэн заалтууд нь дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрөөр дамжин хэрэгжиж байхаар төлөвлөж байна.

УИХ-аас Улс орны хөгжлийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох чиглэл гарч Эдийн засгийн хөгжлийн яамнаас Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуулийн төслийг Эдийн засгийг идэвхжүүлэх 100 хоногын хүрээнд УИХ-д өргөн барихаар ажиллаж байна. Хуулийн төсөлд тусгаснаар нийгэм эдийн засгийн салбар бүр урт хугацааны хөгжлийн бодлоготой байх ба бодлого нь дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрүүдээр дамжин хэрэгжиж байхаар төлөвлөсөн байна.

Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулахдаа тус хуулийн төсөлтэй уялдсан байхаар төлөвлөж байна.



## **ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО**

### **2015-2030**

#### **1. Оршил**

Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого нь улс орны эрчим хүчний аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, ард иргэдийн ая тухтай амьдрах орныг бүрдүүлэхэд орших ба үүний тулд баримтлах бодлого, арга замыг тодорхойлно.

Анхдагч эрчим хүчний олборлолт, нөөц бүрдүүлэлт, эрчим хүчний үйлдвэрлэл, хангалтын үйл ажиллагаа, хөгжлийг төлөвлөх, эрчим хүчний системийн үр ашгийг дээшлүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, чөлөөт зах зээлийн зарчмаар ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх, салбарын эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, түүнийг төгөлдөржүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэхэд энэхүү бодлогын баримт бичгийг үндэслэл болгоно.

#### **2. Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын тулгуур зарчим, хөгжлийн алсын хараа**

Алсын хараа

Улсын орны эдийн засгийн өсөлт, тогтвортой хөгжил, эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай ажилгааг бүрэн хангаж, хувийн хэвшил, өрсөлдөөнт зах зээлд суурилсан үр ашигтай, хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи бүхий, эрчим хүч экспортлох чадамжтай орон болохоор зорьж байна.

Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлогод дараах **тулгуур зарчмуудыг** баримтална:

- Улс орны эрчим хүчний аюулгүй байдлыг хангах;
- Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах;
- Ард иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлсэн байх;
- Байгаль орчинд ээлтэй байх;
- Үр ашиг, хэмнэлттэй байх;
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан байх;
- Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд тулгуурласан байх.

#### **3. Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын стратегийн зорилго**

Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогод дараах **стратегийн зорилгуудыг** тавьж байна. Үүнд:

**Аюулгүй байдлыг хангах хүрээнд:**

1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангана;
2. Бүс нутгийн эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ;
3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог хөгжүүлж, чадавхийг бэхжүүлнэ;

**Үр ашгийг дээшлүүлэх хүрээнд:**

4. Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ;
5. Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллуулна;
6. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлнэ;

**Байгаль орчноо хамгаалах хүрээнд:**

7. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна.
8. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ;
9. Шинэ төрлийн эх үүсвэр, цэвэр технологийг хөгжүүлнэ;

**4. Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын зорилтууд**

Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого, стратегийн зорилгыг хэрэгжүүлэх дараах **зорилтуудийг** дэвшүүлж байна. Үүнд:

**Стратегийн зорилго 1. Эрчим хүчний найдвартай хангамж, аюулгүй байдлыг хангах хүрээнд:**

**Зорилт 1.** Анхдагч эрчим хүчний аюулгүйн нөөцийг бүрдүүлэх;

**Зорилт 2.** Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн аюулгүйн нөөцийг бий болгох;

**Зорилт 3.** Эрчим хүчний эх үүсвэр, хангамжийн үндсэн нөөц нь нүүрс байх бөгөөд бусад нөөцийн оролцоог нэмэгдүүлэх;

**Зорилт 4.** Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах;

**Зорилт 5.** Бүс нутгийн эрчим хүчний системүүдийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар холбож эрчим хүчний нэгдсэн систем байгуулах;

**Зорилт 6.** Эрчим хүчний нэгдсэн системийн цахилгаан ачааллын хэлбэлзлийг тохируулж хэвийн найдвартай ажиллагааг хангах тохируулгын эх үүсвэрүүдийг бий болгох;

**Зорилт 7.** Цахилгаан, дулааны дамжуулах сүлжээ болон диспетчерийн үндэсний зохицуулалт нь төрийн мэдэлд байна;

**Зорилт 8.** Эрчим хүчний салбарт төр, хувийн хэвшлийн оролцооны оновчтой харьцааг хадгалах....

**Стратегийн зорилго 2. Бүс нутгийн эрчим хүчний харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд:**

**Зорилт 1.** Нүүрс, нар салхины нөөцөд тулгуурлан том чадлын цахилгаан станцуудыг барьж Азийн нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх;

**Зорилт 2.** Хөрш орнуудтай эрчим хүч импортлох, экспортлох урт хугацааны харилцан ашигтай ерөнхий хэлэлцээр байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

**Зорилт 3.** Бүс нутгийг холбосон эрчим хүчний транзит шугамыг хөгжүүлэх;

**Зорилт 4.** Экспортын зорилгоор хөрөнгө оруулагчид эрчим хүчний эх үүсвэр барих үйл ажилгааг дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах;

**Зорилт 5.** Олон улсын эрчим хүчний байгууллагууд, бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагааны санал санаачилгад идэвхитэй оролцох, хамтран ажиллах;

**Зорилт 6.** Эрчим хүчний чиглэлээр олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах.....

**Стратегийн зорилго 3. Эрчим хүчний салбарын хүний нөөцийг бэлтгэх тогтолцоог хөгжүүлж, чадавхийг бэхжүүлэх хүрээнд:**

**Зорилт 3.** Эрчим хүчний инженер бэлтгэх дотоодын боловсролын байгууллагуудын чадамжийг олон улсын төвшинд хүргэх

**Зорилт 1.** Эрчим хүчний эдийн засаг, үйлдвэрлэл, туршилт тохируулгын судалгаа хөгжлийн үндэсний хүрээлэнгүүдийг хөгжүүлэх чадавхыг бэхжүүлэх;

**Зорилт 2.** Эрчим хүчний мэргэжилтэй ажилчид, инженер техникийн ажилтан, менежерүүдийг бэлтгэх, мэргэшүүлэх цогц системийг бий болгох.....

**Стратегийн зорилго 4. Эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд:**

**Зорилт 1.** Үндэсний хэмжээнд эрчим хүчний хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, нэгдсэн тогтолцоог бий болгох;

**Зорилт 2.** Эрчим хүч хэмнэх, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг санаачлах, дэмжих;

**Зорилт 3.** Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх сүлжээн дэх алдагдлыг бууруулах;

**Зорилт 4.** Эрчим хүчний үр ашигтай ухаалаг сүлжээг бий болгох;

**Зорилт 5.** Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн чадал хуваарилах, горим тохируулах үйл ажиллагааг эдийн засгийн үр ашигтай диспетчерийн нэгдсэн зохицуулалтаар хангах;

**Зорилт 6.** Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах эрчим хүчний эзлэмжийн хувь хэмжээг бууруулах;

**Зорилт 7.** Эдийн засгийн үр ашиггүй шугам барихыг хориглох.....

**Стратегийн зорилго 5. Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллуулах хүрээнд:**

**Зорилт 1.** Эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх;

**Зорилт 2.** Өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээг хангахад хувийн хөрөнгөөр цахилгаан дулааны эрчим хүчний эх үүсгүүрийг барьж бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд чөлөөтэй худалдах, гадаадад экспортлохыг дэмжих;

**Зорилт 3.** Эрчим хүчний салбарыг өрсөлдөөнт, чөлөөт зах зээлийн зарчмаар ажиллуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

**Зорилт 4.** Бодит өртөг, ашигт тулгуурласан үнэ, тарифын тогтолцоог бий болгож салбарын санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх;

**Зорилт 5.** Нэгдсэн сүлжээнд холбогдох боломжгүй бүсэд эрчим хүчний эх үүсвэрийг хувийн хөрөнгө оруулалтаар барихыг дэмжих;

**Зорилт 6.** Импортыг орлох эрчим хүчний тоног төхөөрөмж, бараа материалын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих.....

**Стратегийн зорилго 6. Эрчим хүчний салбарт инноваци, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх хүрээнд:**

**Зорилт 1.** Эрчим хүчний төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд байгаль орчинд ээлтэй, үр ашигтай шинэ технологийг ашиглах;

**Зорилт 2.** Цахилгаан, дулааны үйлдвэрлэлд нүүрсийг үр ашигтай, хаягдал багатайгаар шатаах технологитой хэт өндөр даралтын параметрт шилжих;

**Зорилт 3.** Эрчим хүчний салбарын шинжлэх ухаан, инновацын технологийн судалгааны чадамжийг бэхжүүлэх;

**Зорилт 4.** Эрчим хүчний нэгдсэн системийн удирдлага, хяналт мэдээллийн цогц системийг ухаалаг технологид шилжүүлэх;

**Зорилт 5.** Шинэ бүтээл, инноваци, дэвшилтэт технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжих, урамшуулах....

**Стратегийн зорилго 7. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүрээнд:**

**Зорилт 1.** Байгаль орчинд ээлтэй, техник технологи нэвтрүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна;

**Зорилт 2.** Эрчим хүчний үйлдвэрлэлээс гарах хаягдлыг эдийн засгийн үйл ажиллагаанд дахин ашиглахыг дэмжих;

**Зорилт 3.** Байгаль орчны нөлөөллийн хяналтыг сайжруулах;

**Зорилт 4.** Олон улсын хүлэмжийн хийн худалдаанд идэвхитэй оролцох....

### **Стратегийн зорилго 8. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хүрээнд:**

**Зорилт 1.** Монгол орны сэргээгдэх эрчим хүч (нар, салхи, ус, газрын гүний дулаан, биомасс зэрэг)-ний нөөцийг тодорхойлж, мэдээллийн санг бүрдүүлэх;

**Зорилт 2.** Эрчим хүчний үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 %, 2030 онд 30 % хүртэл нэмэгдүүлэх;

**Зорилт 3.** Сэргээгдэх эрчим хүчний хөгжлийн гол тулгуур нь усны эрчим хүч байх;

**Зорилт 4.** Нүүрсний экспортын орлогоос сэргээгдэх эрчим хүчний сангийн хуримтлалыг бий болгож урт хугацааны тогтвортой хөгжлийг хангана;

**Зорилт 5.** Алслагдсан суурин, баг, бие даасан хэрэглэгчийн эрчим хүчний хангамжид нар, салхи, биомасс, шингэн болон хийн түлш, газрын гүний дулаан, түлшний элемент, бусад шинэ эх үүсвэрүүдийг ашиглахыг дэмжих;

**Зорилт 6.** Бага оврын сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр бүхий хэрэглэгч түгээх сүлжээнд холбогдох, илүүдэл эрчим хүчээ нийлүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.....

### **Стратегийн зорилго 9. Шинэ эх үүсвэр, цэвэр технологийг хөгжүүлэх хүрээнд:**

**Зорилт 1.** Байгалийн хийг эрчим хүчний үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

**Зорилт 2.** Нүүрсний цэвэр технологийг хөгжүүлэх;

**Зорилт 3.** Эрчим хүчийг нөөцлөх технологиудыг нэвтрүүлэх;

**Зорилт 4.** Нэн шинэ эрчим хүчний эх үүсвэрүүдийг хөгжүүлэх.....

## **5. Бодлогыг хэрэгжүүлэх удирлага, зохион байгуулалт, үнэлгээ**

Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг УИХ дөрвөн жил тутам батлах ба дунд хугацааны хөтөлбөрийг хангах арга хэмжээг ЗГ өөрийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжилд эрчим хүчний нөлөөлөх нөлөөлөл, үр дүнг хянах шалгуур үзүүлэлтийг Засгийн газраас батална.

Монгол улсын эдийн засгийн эрчимтэй хөгжил, шинжлэх ухаан, технологийн ололт, байгаль орчны өөрчлөлт зэргийг харгалзан 10 жил тутамд шинэчлэн тодотгож болно.

“Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлого”-ын биелэлтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээг хоёр жил тутам хийж, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулдаг байхаар төлөвлөж байна.

## 6. Эрчим хүчний салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат

Стратегийн зорилтуудыг 2 үндсэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

**1-р үе шат 2015-2020 он:** Эрчим хүчний нөөцийг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх суурийг бий болгох, эрх зүйн орчныг сайжруулах үе.

Монгол улсын эрчим хүчний эх үүсвэрүүдийн суурилагдсан чадлыг 2 дахин нэмэгдүүлж, үр ашиг өндөртэй өндөр параметрийн тоноглолуудыг ашиглаж эхлэх ба нийт суурилагдсан чадлын 10 аас доошгүй хувийг усны эх үүсвэрээр бүрдүүлж, нөөц чадалыг 10 хувьд хүргэн, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Өндөр хүчин чадал дамжуулах чадвартай, ухаалаг цахилгаан дамжуулах шугамыг барьж, хяналт мэдээллийн цогц удирдлага бүхий эрчим хүчний нэгдсэн системийг бий болгоно.

**2-р үе шат 2020-2030 он:** Эрчим хүч экспортлох чадамжтай болох, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх үе.

Азийн нэгдсэн сүлжээнд холбогдсон, хувийн хөрөнгө оруулалтаар цахилгааны эрчим хүчний эх үүсгүүрийг барьж бүтээгдэхүүнээ дотоодын зах зээлд чөлөөтэй худалдах, гадаадад экспортлох нөхцөл бүрдсэн байна. Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ нийт суурилагдсан чадлын 30 хувьд хүрнэ. Монгол улсын эрчим хүчний эх үүсвэрийн аюулгүйн нөөц 20 хувь хүрч эдийн засгийн хөгжлийг ханган бие даан хөгжих чадамжтай болсон байна.

## 7. Хүрэх үр дүн

Стратегийн 1 дүгээр зорилгын хүрээнд:

- Эрчим хүчний аюулгүйн нөөц 20 хувь хүрч, эрчим хүчний салбарын найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг ханган эдийн засгийн тогтвортой хөгжлийг бүрэн хангана.
- Эрчим хүчний хүртээмжтэй байдлыг 100 хувьд хүргэнэ (Бүх иргэд эрчим хүчээр хангагдна)

Стратегийн 2 дүгээр зорилгын хүрээнд:

- Эрчим хүчний мега төслүүдийг хэрэгжүүлж эрчим хүч экспортлогч орон болсон байна
- Зүүн хойд болон өмнөд Азийн бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаанд идэвхитэй оролцогч болсон байна.

Стратегийн 3 дугаар зорилгын хүрээнд:

- Инноваци, өндөр технологийн үндэсний хүрээлэнгүүдтэй болсон байна.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний мэргэжилтэй боловсон хүчинтэй болсон байна

Стратегийн 4 дугаар зорилгын хүрээнд:

- Эрчим хүчний үйлвэрлэлийн дотоод хэрэгцээг 15 хувь, дамжуулалт түгээлтийн алдагдлыг 20 хувь, барилгын дулааны алдагдлыг 50 хувь бууруулна.
- Нэгж бүтээгдхүүнд ноогдох эрчим хүчний эзлэмжийг 2 дахин бууруулна

Стратегийн 5 дугаар зорилгын хүрээнд:

- Эрчим хүчний салбар чөлөөт зах зээлийн зарчмаар ажиллаж санхүүгийн хувьд бие даасан байна.
- Үнэ тарифийг бүрэн индексжүүлсэн байна.
- Түгээх хангах сүлжээ бүрэн хувьчлагдсан байна.
- Эрчим хүчний эх үүсвэрийн суурилагдсан чадал, үйлдвэрлэлд хувийн хэвшлийн хувь оролцоо давамгайлна.

Стратегийн 6 дугаар зорилгын хүрээнд:

- Ultra Super Critical, Advanced UltraSuper Critical технологиудыг нэвтрүүлсэн байна.
- Эрчим хүчний ухаалаг сүлжээг бий болно
- Инноваци, дэвшилтэт технологийн хүрээлэнгүүдийн бүтээлийг үйлдвэрлэл, хэрэглээнд шууд нэвтрүүлдэг болох

Стратегийн 7 дүгээр зорилгын хүрээнд:

- 1 кВтц эрчим хүчинд ноогдох хүлэмжийн хийн ялгарлыг 20 хувь бууруулна
- Эрчим хүчний үйлдвэрлэлийг байгаль орчинд ээлтэй болгоно.

Стратегийн 8 дүгээр зорилгын хүрээнд:

- Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээ нийт суурилагдсан чадлын 30 хувьд хүрнэ.
- Малчин өрх ахуйн хэрэглээгээ сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр 100 хувь хангадаг болно.

Стратегийн 9 дугаар зорилгын хүрээнд:

- Сэргээгдэх эрчим хүчний нийт эх үүсвэрийн 20 хувийг нөөцлөх боломжтой болсон байна.
- Эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтцэд нүүрснээс бусад эх үүсвэрийн эзлэх хэмжээг 50 хувьд хүрсэн байна.

## **8. Бодлогыг хэрэгжүүлэх санхүүжилтын эх үүсвэр**

Төрийн болон олон улсын санхүүгийн байгууллага, хувийн хэвшлийн эрчим хүчний салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих санхүүгийн механизмыг бэхжүүлэн сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхэд ашиглана.

Бодлогыг хэрэгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөрийг:

- Улсын төсөв, хөрөнгө оруулалтын хөтөлбөр,



- Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа,
- Хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах
- Олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэг
- Зээл тусламжийн бодлого-д

тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### **Дунд хугацааны хөтөлбөр**

**2015-2021**

Дунд хугацааны хөтөлбөр нь Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болно. Хөтөлбөрт тодорхой бодит төсөл, хөтөлбөрүүдийг тусгах ба дотроо дэд хөтөлбөрүүдтэй байж болох юм. Дунд хугацааны хөтөлбөр нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль болон салбар хоорондын төлөвлөлттэй уялдах бөгөөд засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдан хэрэгжиж байх юм.